



2023 он

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

MSC виртуал хөрөнгийн цахим худалдааны цогц шийдэлтэй
“Market.shop” платформ хөгжүүлэх төсөл

АГУУЛГА

Төслийн хэрэгжилтийн хураангуй	3
Төслийн хийгдсэн ажлын дэлгэрэнгүй	7
Токеномист	10
Санхүүгийн үр дүн	12

ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХУРААНГУЙ

Төслийн товч танилцуулга

MSC виртуал хөрөнгө

- Аривайз ХХК нь 2021 оны 12 дугаар сарын 09 өдөр Marketshop coin (MSC) виртуал хөрөнгийг “цахим худалдааны цогц шийдэлтэй платформ” болох
- Маркетшоп технологийн төсөл хэрэгжүүлэхээр олон нийтэд санал болгосон.
- Нийт 498,258,823 төгрөгийн хөрөнгө татан төвлөрүүлж 2022 оны 1 дүгээр сарын 14 өдөр Капекс бирж дээр хоёрдогч зах зээлийн арилжаанд оруулсан.

Татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах төлөвлөгөө

- Татан төвлөрүүлсэн хөрөнгөөр Маркетшоп төслийг үе шаттайгаар санхүүжүүлнэ.
- Татан төвлөрүүлсэн хөрөнгийн Маркетшоп төсөлд хараахан ашиглагдаагүй байгаа хэсгийг Market.mn - ийн эргэлтэд Маркетшоп төсөл рүү татах хүртэлх хугацаагаар оруулж ашгаар нь виртуал хөрөнгө эзэмшигчиддээ эхний сараас эхлэн өгөөж олгоно.
- Market.shop төсөл амжилттай хэрэгжиж эхэлснээр өөрөөсөө виртуал хөрөнгө эзэмшигчиддээ өгөөжөө олгоод явна.

Маркетшоп төслийн зорилго

- Маркетшоп төсөл нь цахим худалдааны цогц шийдэлтэй програм хангамжийг бүтээж жижиг, дунд худалдаа эрхлэгчид програм хөгжүүлэгчийн тусламжгүйгээр бие даан богино хугацаанд цахим дэлгүүрээ үүсгэн амжилттай ажиллах боломжийг олгох зорилготой.
- Бид энэхүү төслөө нэгдүгээрт Монголын зах зээлд амжилттай нэвтрүүлэх, хоёрдугаарт үндэсний үйлдвэрлэл эрхлэгчид гадаад зах зээлд бүтээгдэхүүнээ цахимаар борлуулах үйл ажиллагааных нь технологийн түнш байх, гадаад зах зээлд програм хангамжаа нэвтрүүлэх алсын хараатай.

Маркетшоп платформ нь дараах дэд системүүдээс бүрдэнэ.




Төслийн хийгдсэн ажлын хураангуй

Д/Д	Хугацаа	Хийгдсэн ажил
1	2022.02 сар	Маркетшоп төслийн программын хөгжүүлэлт эхэлсэн
2	2023.04 сар	“Маркетшоп худалдааны технологи” ХХК – г байгуулсан
3	2023.03 сар	Хөгжүүлэлтийн эхний үе шат дууссан Тест, нэвтрүүлэлтийн ажил эхэлсэн
4	2023.07 сар	Хүргэлтийн аппликэйшн хөгжүүлэлт эхэлсэн
5	2023.10 сар	Маркетшоп платформ албан ёсоор нээлтээ хийсэн
6	2023.12 сар	Хүргэлтийн аппликэйшн ашиглалтад орсон
7	2023.12 сар	Борлуулалтын орлого авч эхэлсэн

Төслийн хөрөнгө оруулалтын зарцуулалт


Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт 2023 оны 12 сарын 31 өдрийн байдлаар:



- 425,308,415 төгрөг буюу 85%-ийг Маркетшоп төслийн хөгжүүлэлт, нэвтрүүлэлтэд зарцуулсан,
- 72,950,408 төгрөг буюу 15%-ийг Маркет.мн-ийн эргэлтийн хөрөнгөөр ашиглаж байна.

Виртуал хөрөнгө эзэмшигчдэд өгсөн өгөөж

- MSC виртуал хөрөнгө эзэмшигчдэд 2022 оны 1-р сараас 2023 оны 12 сар дуустал бүх саруудад тасралтгүй өгөөж олгосон.
- Ингэхдээ виртуал хөрөнгийн анх олон нийтэд санал болгосон үнээр (1 MSC = 0.25₮) тооцон эзэмшиж буй виртуал хөрөнгийн дүнгийн 2%-р өгөөж олгосон.
- 2022 онд 103,691,191 төгрөг
- 2023 онд 48,875,574 төгрөгийн өгөөж тус тус олгосон.



ТӨСЛИЙН ХИЙГДСЭН АЖЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ

Төслийн баг

MSC (Маркетшоп койн) виртуал хөрөнгийг Аривайз ХХК-с олон нийт санал болгож төслийг эхлүүлсэн.

Төсөл эхэлснээс хойш тухайн төслийн технологи хөгжүүлэлтийн баг хувьцаа эзэмшигчээр нэмэгдсэн, санхүүгийн орлого зарлага, үр дүнг тусад нь бүртгэж тайлагнах зэрэг шалтгаанаар 2023 оны 4 дүгээр сард “Маркетшоп худалдааны технологи” ХХК – ийг байгуулсан.

Төслийн хөгжүүлэлтийн үе шатанд төслийг санаачлагч Аривайз ХХК-ийн бизнесийн баг хөгжүүлэлт, түүний үйл ажиллагаанд бизнес талаас оролцон ажилласан.



2023 оны 10 сараас төслийн маркетинг, борлуулалтын багт маркетингийн менежер, борлуулалтын менежер, вэб дизайнер зэрэг ажлууд нэмэгдэн баг үйл ажиллагааны баг бүрдсэн. Нийт 13 ажилтантай баг ажиллаж байна. Санхүү, хүний нөөц, дизайн, маркетингийн үйл ажиллагаанд Аривайз ХХК-с дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Маркетинг, борлуулалтын хүрээнд хийгдсэн ажлууд

Төслийн маркетинг борлуулалтын үйл ажиллагаа 2024 оны 10 сараас баг үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Виртуал хөрөнгийн төсөл болох Маркетшопын идэвхжүүлэлт, борлуулалт дээр ажилласан.

Хийгдсэн гол ажлууд:


- Цахим худалдаа монгод Подкаст эхлүүлсэн
- Төслийн лого, брэндбүүкийг дахин хийж рибрендинг хийсэн
- Өөрсдийн харилцагчийг удирдах систем CRM-ийн эхний хувилбарыг хөгжүүлэн ашиглаж эхэлсэн
- Вэбдизайны дэмжлэг хэрэгтэй, вэбсайтаа мэргэжлийн дизайнераар өрүүлээх хэрэгцээтэй харилцагч нар зориулан 1 жилээр төлбөр урьчилан төлөх багцын үйлчилгээг гарган харилцагч нартаа санал болгосон.
- Вэбсайтаа өөрөө үнэгүй бүтээх онлайн сургалт бэлтгэн сар бүр явуулахаар сургалтыг эхлүүлсэн

Үр дүн:

- 12 харилцагчтай болсон
- 12 дугаар сараас хэрэглэгчээс борлуулалтын орлого авч эхэлсэн, тухайн сардаа 5 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн

Хөгжүүлэлтүүд хүрээнд хийгдсэн гол ажлууд

2022 оны тайлан буюу whitepaper 2.0-д тусгагдсан хөгжүүлэлтийн төлөвлөгөөний хэрэгжилтийг доорх хүснэгтээр тусгав.



ТОКЕНОМИСТ

Блокчэйний төрөл

- Market Shop Coin (MSC) нь Binance Smart Chain блокчэйн протокол дээр суурилсан BEP-20 стандартын токен
- Блокчэйн нь бүрэн хөгжүүлэлт хийгдэж аюулгүй байдлыг хангасан бөгөөд 2022 оны 3-р сард “Инфосек интележинс” ХХК-аар технологийн аудит хийлгэсэн. 2022 оны 3 сараас хойш блокчэйний хөгжүүлэлт хийгдээгүй, үндсэн төслийн платформын хөгжүүлэлтүүд хийгдсэн.

Виртуал хөрөнгийн нийтэд санал болгох үнэ, хэмжээ:

- Нэгж MSC койны үнэ: 0.25 төгрөг
- Нийтэд санал болгох санал болгох нийт дүн: 7.5 тэрбум төгрөг

Нийтэд санал болгох виртуал хөрөнгө тоо хэмжээ:

Гадаад зах зээлд нэвтрэх нөөц (2 жилийн түгжээтэй)	30,000,000,000 койн	30%
Хамтын ажиллагаа	5,000,000,000 койн	5%
Market.mn 400,000 хэрэглэгчийн урамшуулал	4,000,000,000 койн	4%
Гадаад зах зээлд нэвтрэх нөөц (2 жилийн түгжээтэй)	35,000,000,000 койн	35%
Төслийн баг (3 жилийн түгжээтэй)	11,000,000,000 койн	11%
Хөрвөх чадварын нөөц	15,000,000,000 койн	15%
Нийт нийлүүлэлт	100,000,000,000 койн	100%

Виртуал хөрөнгийн хэрэглээ

- Биржийн арилжаанд оролцох
- Market.mn болон market.shop төслүүдээс өгөөж авах
- Market.mn болон market.shop төслүүдийн эко системд худалдан авалт хийх, урамшуулал авах, хадгаламж зээлийн /staking/ үйлчилгээ авахад ашиглах

Виртуал хөрөнгийн хуваарилалт, тархалтын мэдээлэл

- 2023 оны 12 дугаар сарын 31 өдрийн байдлаар MSC койны хуваарилалт, тархалтын мэдээлэл


Арилжих боломжтой койн эзэмшигчдэд байгаа койны тоо	1,964,619,185 койн
Market.mn 400,000 хэрэглэгчийн урамшуулал (Түгжээтэй)	220,920,000 койн
Төслийн баг (3 жилийн түгжээтэй)	24,407,500 койн
Аривайз ХХК	1,249,716,107 койн
Нийт нийлүүлэлт	3,484,362,792 койн

САНХҮҮГИЙН ҮР ДҮН

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт

MSC (Market Shop Coin) виртуал хөрөнгийг Market.shop төслийг санхүүжүүлэхээр анхдагч зах зээл дээрээс нийт 7.5 тэрбум төгрөг татан төвлөрүүлэх зорилго тавиад түүний 6.64 хувьтай тэнцэх буюу 498,258,823 төгрөг татан төвлөрүүлсэн.

Market.shop	Үйл ажиллагааны зардал	24,755,945	5.8%
Market.shop	Технологи хөгжүүлэлт	323,948,787	76.2%
Market.shop	Маркетингийн зардал	3,653,275	0.9%
Market.mn	Эргэлтийн хөрөнгө	72,950,408	17.2%



Төслийн орлого, үр дүн

Үзүүлэлт	2022	2023	Нийт
Борлуулалтын орлого	-	5,024,450	5,024,450
Үйл ажиллагааны зардал:	207,748,385	204,975,753	412,724,137
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	12,584,278	12,584,278
Нийт зардал	(207,748,385)	(217,560,031)	(425,308,415)
Үйл ажиллагааны нийт цэвэр ашиг	(207,748,385)	(212,535,581)	(420,283,965)